



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/310

Хэрлэн сум

Хянан магадлагааны ажилд
Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, 63 дугаар зүйлийн 66.1, Малын генетик, нөөцийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 18 дугаар зүйлийн 18.3.1 дахь заалт, 2020 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 дугаар хуралдааны “аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоол, 2021 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дугаар хуралдааны “аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дадал суманд үржүүлэгдэж буй мах-сүүний хосолмол ашиг шимтэй үхрийг “үүлдэр”-ээр баталгаажуулахад хянан магадалгаа хийх, ажилд зориулж 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх захирамжын зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
дугаар сарын 13-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын Гооцоо

№	Шагналын нэр, төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	нийт дүн
1	Ажлын хөлс	6 хүн/7 хоног	250,000	1,500,000
Нийт				1,500,000